



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 1187

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Авга ач нар” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сонголт-3, Хүслэн үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Төгөлдөр (Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл (Аймгийн ерөнхий архитекторын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ш.Даваадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

Б.Эрдэнэцэцэг (Эрүүл мэндийн газрын Эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч)

С.Өнөржаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Н.Ням-Эрдэнэ (“Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер)

Д.Алтанхуяг (“Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХХК-ийн кабель, шугамын инженер)

Б.Бямбатөмөр (“Ховд дулааны станц” ТӨХК-ийн ерөнхий инженер)

М.Нансалмаа (“Шим-Ус” ОНӨААТҮГ-ын ерөнхий инженер)

Ц.Энх-Амгалан (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн хяналтын инженер)

Б.Одсүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Хяналтын инженер)

К.Нэргүй (Тэргэнцэртэй иргэдийн холбооны салбар зөвлөлийн тэргүүн)

С.Батдорж (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

С.Тайванбаатар (“Жаргалант хийц” ХХК-ийн захирал)

Г.Батбаяр (Авга ач нар ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн

дарга:

Б.Жамбалдорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт “Сонголт-3, Хүслэн үйлчилгээний төв”-ийн барилгыг ашиглалтад оруулахад ажлын тоо хэмжээ, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга (Б.Төгөлдөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Э.УРТНАСАН